# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр Дугаар 434 Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 9,707,667,809.64 (есөн тэрбум долоон зуун долоон сая зургаан зуун жаран долоон мянга найман зуун есөн төгрөг жаран дарван мөнгө) төгрөгийн балансын үнэтэй хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Таван тогойн түлш” хязгаарлагдмал хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Бямбаахүү, “Таван толгойн түлш” хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА А.АРИУНБОЛД

0000882

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
434 дугаар тогтоолын хавсралт

# "ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИАС "ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| ДД | Хөрөнгийн нэр | Хүлээн авсан огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Балансын үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Шахмал түлшний барилга | 2017.01.01 | ком | 1 | 2,608,982,662.54 |
| 2 | Шахмал түлшний агуулах | 2017.01.01 | ком | 1 | 523,598,719.56 |
| 3 | Хатаах тоног төхөөрөмж-1 | 2017.01.01 | ком | 1 | 706,030,550.58 |
| 4 | Хатаах тоног төхөөрөмж-2 | 2017.01.01 | ком | 1 | 675,336,072.65 |
| 5 | Кокс хэлбэржүүлэгч | 2017.01.01 | ком | 2 | 242,960,861.30 |
| 6 | 2 голт шнекэн холигч | 2017.01.01 | ком | 4 | 142,062,136.20 |
| 7 | Тээрэм-1 | 2017.01.01 | ком | 1 | 381,061,668.49 |
| 8 | Тээрэм-2 | 2017.01.01 | ком | 1 | 422,748,146.67 |
| 9 | Циклон-1 | 2017.01.01 | ком | 1 | 127,403,458.79 |
| 10 | Циклон-2 | 2017.01.01 | ком | 1 | 77,308,354.72 |
| 11 | Калорифер уурын | 2017.01.01 | ком | 2 | 177,897,516.42 |
| 12 | Вентилятор /хатаагчийн/ | 2017.01.01 | ком | 2 | 103,350,749.60 |
| 13 | Хөргөлтийн усны бак | 2017.01.01 | ш | 1 | 21,540,142.94 |
| 14 | Үнс шигшигч | 2017.01.01 | ком | 1 | 34,007,389.17 |
| 15 | Элеватор /хутгуурт/ | 2017.01.01 | ком | 1 | 141,449,202.97 |
| 16 | Элеватор /хутгуурт/ | 2017.01.01 | ком | 1 | 106,449,978.42 |
| 17 | Утаа сорогч-1 | 2017.01.01 | ком | 1 | 103,042,313.57 |
| 18 | Утаа сорогч-2 | 2017.01.01 | ком | 1 | 87,830,214.64 |
| 19 | Араат насос | 2017.01.01 | ком | 2 | 38,821,117.64 |
| 20 | Спираль тээвэрлэгч | 2017.01.01 | ком | 11 | 331,698,568.85 |
| 21 | Туузан конвейр | 2017.01.01 | ком | 12 | 251,399,861.04 |
| 22 | Хадгалах бункер.400м/куб | 2017.01.01 | ком | 2 | 235,954,361.28 |
| 23 | Завсрын бункер.65м/куб | 2017.01.01 | ком | 2 | 176,504,587.90 |
| 24 | Кокс хүлээн авах бункер.12м/куб | 2017.01.01 | ком | 1 | 75,076,834.73 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 25 | Үнс хүлээн авах бункер.12м/куб | 2017.01.01 | ком | 1 | 75,076,834.73 |
| 26 | Вентилятор /тоос сорох/ | 2017.01.01 | ком | 2 | 7,366,064.48 |
| 27 | Вентилятор | 2017.01.01 | ком | 1 | 4,405,553.81 |
| 28 | Хэргэлтийн усны бак | 2017.01.01 | ком | 1 | 3,956,537.86 |
| 29 | Ялтсан бойлертэй узель | 2017.01.01 | ком | 1 | 92,539,952.30 |
| 30 | Шингэн хадгалах сав./бак 440м.куб/ | 2017.01.01 | ш | 1 | 204,564,902.44 |
| 31 | Цогцолборын шахмал түлшний үйлдвэрийн хаалттай дэд станц, холбоо дохиолол, гэрэлтүүлгийн тоноглол | 2017.01.01 | ком | 1 | 711,180,642.68 |
| 32 | Шахмал түлшний үйлдвэрийн дулаан хангамжийн тоноглол | 2017.01.01 | ком | 1 | 678,179,579.72 |
| 33 | Шахмал түлшний үйлдвэрийн бохирын усны систем | 2017.01.01 | ком | 1 | 52,673,511.96 |
| 34 | Самосволь | 2017.01.01 | ш | 1 | 85,208,758.99 |
| **Нийт дүн** | | | | 65 | 9,707,667,809.64 (есөн тэрбум долоон зуун долоон сая зургаан зуун жаран долоон мянга найман зуун есөн төгрөг жаран дөрвөн мөнгө) |